

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код:.....

Өргөн нэвтрүүлгийн нэр томъёоны стандарт - Хөтөлбөр	MNS-.....
Broadcast Terminology Standards - Programm	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 20... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандартаар Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэхтэй холбоотой нэр томъёог тодорхойлсон.

2. Норматив эшлэл

Энэхүү стандартад дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшлэлийн хувьд эш татсан хэвлэл, харин хугацаа заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ.

- *Олон нийтийн радио телевизийн тухай хууль*
- *Зар сурталчилгааны тухай хууль*
- *Зохиогчийн эрх, түүн хамаарах эрхийн тухай хууль*
- *Өргөн нэвтрүүлгийн зохицуулалт, нөхцөл шаардлага, ХХЗХ*
- *MNS 4907, Кабелийн телевизийн сүлжээний техникийн үндсэн шаардлага*
- *MNS 5591-1, Радиогийн студи 1-р хэсэг: Үндсэн шаардлага*
- *MNS 5591-2, Радиогийн студи 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага*
- *MNS 5592-1, Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага*
- *MNS 5592-2, Тоон телевизийн студи. 2-р хэсэг: Тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага*

- *Телевизийн сэтгүүл зүй, үндсэн ойлголт, зөвлөмж – Х. Наранжаргал, 2006*
- *Телевизийн тухай А-Я хүртэл (тайлбар толь) – Г.Мэндхүү, Т.Өнөрсайхан, 2014*
- *Радиоогийн тухай А-Я хүртэл (нэр томъёоны тайлбар толь, зөвлөмж) – Д.Батжаргал, Г.Мэндхүү, 2016*
- *The OFCOM broadcasting code*
- *OFCOM Communications Market Report 2018, Methodology & Glossary*
- *The ultimate list of Broadcast journalism terms, New York Film academy, USA*
- *ICA glossary of media terminology: Broadcast & Internet, Institute of Communications and Advertising*
- *Broadcasting Services Act 1992 Australia*
- *Law On Television and Radio Broadcasting, Ukraine*
- *Broadcast Terminology: The Medialink Broadcasting Glossary*
- *Canadian Radio-television and Telecommunications Commission Act*
- *Georgian law on Broadcasting*
- *Глоссарий рекламных терминалов, Эрлинг-рекламно информационное агентство*
- *Глоссарий, Индустриальный Телевизионный Комитет, Украин*
- *Словарь рекламных терминов, Агентство Стимулирования Продаж, Россия*

3. Нэр томьёо

№	Нэр томьёо	Тайлбар	Англи үг, задаргаа
1	Агаар	Радио, телевизийг радио долгион ашиглан дамжуулах орчин	Air
2	Агаарын өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ/агаарын төлбөргүй ТВ/	Зохицуулах хорооноос Монголын үндэсний олон нийтийн радио, телевизэд олгосон тусгай зөвшөөрөлтэй телевиз, суваг, радиог тоон телевиз, радиогийн газрын дахин дамжуулах сүлжээгээр радио давтамж ашиглан тодорхой хамрах хүрээнд төлбөрийн /Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 17.1.1-д заасан үйлчилгээний хөлс/ үндсэн дээр хэрэглэгчид хүргэх үйлчилгээг хэлнэ.	Free to air
3	Ам барилт	Дуу, дүрс бичлэгийн бүтээлийн яриаг нэг хэлнээс нөгөө хэл рүү орчуулан жүжигчний дуу хоолойгоор амилуулах	Dubbing
4	Аналог Тоон шилжилтийн хугацаа	Телевизийн газрын тоон сүлжээний эхний нэвтрүүлэгчийг асааж эхэлснээс телевизийн газрын өргөн нэвтрүүлгийн болон олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн аналог нэвтрүүлгийн дамжууллыг зогсоох хүртэлх хугацаа	Analog Switch Off (ASO)
5	Анги	Цуврал нэвтрүүлэг, киноны дараалж гарах дугаар	Episode
6	Аниматор		Animator
7	Анимэшн/Хөдөлгөөнт график дүрс	Хөдөлгөөнгүй зураг, дүрсийг хөдөлгөөнд оруулж, амьлуулах үйл явц	Animation
8	Аннотация/Нэвтрүүлгийн зохиол	Нэвтрүүлгийн зорилго, төрөл жанр, хугацаа, хэнд чиглэсэн зэрэг үндсэн мэдээллийг агуулсан товч танилцуулга	Annotation
9	Арилжаа сурталчилгааны мэдээлэл	Аль нэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх танилцуулгыг багадаа 90 секунд, дунджаар 15 минут хүртэлх хугацаанд хөтлөлттэй сурталчлан таниулах захиалгат, төлбөртэй мэдээлэл өгөх хөтөлбөр. <i>Ийм хөтөлбөрийн эхлэл, төгсгөл болон тухайн мэдээллийн дундуур энэ нь арилжаа сурталчилгааны мэдээлэл гэдгийг тодотгон дүрсээр, үгэн хэлбэрээр илэрхийлсэн, харуулсан байх, үгэн илэрхийллийн арын фон, өнгө, шрифтийн хэмжээ нь үзэгчдэд харагдахуйц, ойлгомжтой, тод байхаар тусгасан байх, хүүхдэд чиглэсэн арилжаа сурталчилгааны мэдээлэл байхгүй байхыг шаарддаг.</i>	Infomercials
10	Арилжаа, сурталчилгааны нэвтрүүлэг	Аливаа бараа, ажил, үйлчилгээг зар сурталчилгааны (реклам) хэлбэрээр бус газар дээрээс нь сурталчилж бизнес мэдээ болон бусад хэлбэрээр бэлтгэсэн сурталчилгааны дагнасан нэвтрүүлэг	Commercial programm
11	Аудио барилт	Аудио дохиог харьцуулах арга. Телевизийн үзэлт хэмжихэд ашиглагддаг технологийн нэг төрөл.	Audio matching

12	Баннер	Телевизорын дэлгэцийн буланд байх сувгийн лого, нэвтрүүлэг, шоуны нэр таних тэмдгийг илэрхийлэх жижиг график дүрслэл	Banner
13	Баримтат мэдээ/гэрчлэх мэдээ/	Баримтат үйл явдлын мэдээ мэдээллийг газар дээрээс нь сурвалжлан, (түүнийг үзэж харсан гэрчлэх этгээдээс яриа авсан, нөхцөл байдлыг дүрсээр харуулсан гм) бэлтгэсэн мэдээ.	Eyewitness news
14	Баримттай нэвтрүүлэг	Бодит баримт, болж буй болон болсон үйл явдалд түшиглэн хийсэн нэвтрүүлэг	Reality programming/Factual program
15	Блок	Үргэлжилсэн тодорхой, хэсэг хугацаа. Голдуу зар сурталчилгааны блок гэдэг утгаар хэрэглэгддэг.	Block / break
16	Бүлэг	ТВ-ийн кино, нэвтрүүлгийн нэг цуврал;	Season
17	Бүтээгдэхүүн байршуулах сурталчилгаа	<p>Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор тухайн бараа бүтээгдэхүүн үйлчилгээний нэр, барааны тэмдэг, үйлдвэрлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны мэдээлэл, уриа, лого зэргийг үгэн болон дүрсэн хэлбэрээр Телевизийн нэвтрүүлгийн үеэр үзүүлсний төлөө төлбөр авах үйл ажиллагаа.</p> <p><i>Тухайн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг төлбөргүй байршуулах нь бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ байршуулах сурталчилгаа хийгээгүй гэж үзэх үндэслэл болохгүй. Зар сурталчилгааны тухай хуулиар хориглосон бараа бүтээгдэхүүн үйлчилгээг бүтээгдэхүүн байршуулах хэлбэрээр сурталчлахыг хориглоно. Нэвтрүүлгийн эхлэл төгсгөл, зар сурталчилгааны завсарлагын дараа Бүтээгдэхүүн байршуулах сурталчилгаа хийгдэж байгаа талаар үзэгч, сонсогчдод тодорхой мэдээлнэ. Цаг үеийн үйл явдлын мэдээ, нийгэмд тулгамдсан асуудлын талаарх мэдээллийн нэвтрүүлэг, зөвлөгөө, хэрэглэгчийн булан нэвтрүүлэг, хүүхдэд зориулсан нэвтрүүлэг, хөтөлбөр, боловсрол танин мэдэхүйн нэвтрүүлэгт бүтээгдэхүүн байршуулах сурталчилгааг хориглоно.</i></p>	Product placement
18	Бүтээл үйлдвэрлэл/Продакшн	Бүтээл үйлдвэрлэл нь телевиз, кино, дижитал видеоны бүтээл үйлдвэрлэлийн 2 дахь үе шат бөгөөд тухайн нэвтрүүлэг киноны зураг авалтыг бүрэн хийж дуусгах бүх үйл ажиллагааг хэлнэ. Үүнд: тайз засал, зураачийн ажил, анхны боловсруулаагүй зураг авалт гэх мэт үүргүүд	Production
19	Бэлэн байдал	Яг шаардлагатай үед нь ажиллах, ашиглахад бэлэн байгаа хүн ба техник хэрэгсэл/эд юмс	Standby
20	Видео сангийн үйлчилгээ	олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгчийн хүсэлтээр видео контентоор хангах үйлчилгээ	Video-on-demand (VoD)
21	Газар дээрээс авсан мэдээ, сурвалжлага	Тухайн үйл явдлын хажууд мэдээ унших,ярилцлага авах процесс	Stand-up
22	Гамшгийн зарлан мэдээлэл	Олон нийтэд хүргэх дохио, сэрэмжлүүлэх мэдээлэл	Emergency alert message

23	Далд сурталчилгаа	Агуулга, хэлбэрийн хувьд зар сурталчилгаа гэж шууд ойлгогдохгүй, хэрэглэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг хэлнэ. Телевизээр бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, барааны тэмдэгт, бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэгчийн үйл ажиллагааны талаар дуу, дүрс, видео хэлбэрээр үзүүлэхдээ олон нийтийг бодит үзүүлж байгаа зүйлээс төөрөгдүүлж, сурталчилгааны зорилгоор ашиглах	Surreptitious advertisement
24	Дуу дүрст мэдээлэл	Дуу авиа бүхий дүрст бүтээл гэж ямар материаллаг хэлбэрт оруулснаас үл шалтгаалан, техник хэрэгсэл ашиглан бүтээсэн дүрсийг дуу авианы хамт үзүүлэх боломжтой бүтээлийг; <i>(Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хууль)</i>	Audiovisual information
25	Дуу дүрст/Дуу дүрсэн	Дуу дүрст/ Дуу дүрсэн	Audiovisual (AV or A.V.)
26	Дуу чимээний/найруулга	Яриа, хөгжим зэрэг бодит эх үүсвэрээс бусад амьтан, ургамал, авто замын хөдөлгөөн, байгаль, цаг уурын чимээ гэх мэт бусад дуу чимээ оруулах	Sound effects (se, s.e., sfx, or s.f.x.)
27	Дууны оператор	Микрофон холбох, байршуулах, хянах гм үүрэгтэй дууны инженерийн туслах ажилтан	Boom operator
28	Дууны эвлүүлэгч	Телевизийн хувьд: дуу эвлүүлэх, дууны замыг тохируулж, засварладаг, дууны ямар эффект ашиглахыг шийдэж, фильтр ашиглаж дуу авиаг засварлах, шинэ дуу үүсгэх, дуу авиануудыг нийлүүлэх, дууны түвшинг тохируулах зэрэг ажил хийдэг	Sound editor/Sound mixer
29	Дуут дохио	Аливаа нэвтрүүлэг, зар сурталчилгааны эхэнд эсвэл засвар (edit) хийх зорилгоор видео хальсын эхэнд өгөх аудио дохио	Beep
30	Дүрсийн найруулагч	Дүрсийн найруулагч нь дүрсийн пульт дээр ажилладаг, студийн камер, сервер, студи-д орж ирсэн гадны эх үүсвэрүүдийн дүрсийг хολих	Vision mixer
31	Дүрсэн дээр дуу унших	Телевизийн нэвтрүүлэг, киноны үндсэн дүрсэн дээр давхар яриа унших, дүрс гарахтай зэрэгцэж тв-ийн нэвтрүүлэгч тайлбар унших	Voice-over (VO)
32	Дэлгэц шахах	Нэвтрүүлэг хооронд ашиглагддаг, дараагийн нэвтрүүлэг эхлэхэд өмнөх нэвтрүүлгийн бүтэн дэлгэцийг жижигрүүлж, дэлгэцийн буланд харагдуулахыг хэлнэ, мастер контроль дээр тохируулах	Squeeze/topic box
33	Жингл	Сурталчилгаанд ашиглагддаг, богино хэмжээний, ихэнхдээ сурталчилгааны уриа ашигласан, сэтгэлд хоногшихуйц дуу, ая бөгөөд брендинг ая, эгшиг болгосон хэлбэр	Jingle
34	Зар сурталчилгаа	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өөрийн бараа, ажил, үйлчилгээний зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны болон олон нийтийн өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогоор төлбөртэй, эсвэл түүнтэй дүйцэхүйц нөхцлөөр дамжуулсан зар мэдээлэл, эсвэл тухайн өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогийн өөрийн хөтөлбөр, нэвтрүүлгийн промо	

35	Зар сурталчилгаа нийлүүлэгч	Бараа, ажил, үйлчилгээнийхээ зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны болон олон нийтийн өргөн нэвтрүүлгийн телевиз, радиогоор төлбөртэй, эсвэл түүнтэй дүйцэхүйц нөхцлөөр дамжуулахаар зар сурталчилгаа захиалж буй байгууллага эсвэл хувь хүн	Advertiser
36	Зар сурталчилгааны агентлаг	Захиалагчийн зар сурталчилгааг бүтээхээс эхлээд түүнийг ямар медиа хэрэгслээр түгээхийг оновчтойгоор төлөвлөж, байршуулж, хянах ажлыг цогцоор нь эсвэл хэсэгчлэн гүйцэтгэдэг бие даасан байгууллага эсвэл захиалагчийн дэргэдэх сурталчилгаа хариуцсан алба	Advertisement Agency / Ad Agency
37	Зар сурталчилгааны хязгаарлалт	Радио, телевизийн хөтөлбөрийг дамжуулах хугацаанд хууль, зохицуулалтаар зөвшөөрөгдөх зар сурталчилгааны хугацаа. Цаг тутамд эсвэл эфирийн хоногийн хугацаанд хэдэн минут байхыг голдуу заасан байдаг.	Commercial load
38	Зураг авсан материал	Зургийн тасралтгүй авсан хугацааны материал	Footage
39	Зүй бус зар сурталчилгаа	Зар сурталчилгааны тухай хуулиар тодорхойлсон - өөрийн барааг бусдынхтай ижилсгэн сурталчилсан; -бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа; - хангалттай тодорхой мэдээллийг орхигдуулан, эсхүл мэдлэг, туршлага дутмаг буюу итгэмтгий байдлыг нь ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан гм шинж чанартай зар сурталчилгаа	Improper advertisement
40	Зэрэг дамжуулалт	Аливаа нэвтрүүлгийг телевиз,радиогоор ижил цагт дамжуулах	Simulcast
41	Ивээн тэтгэгч		Sponsor
42	Ивээн тэтгэгчийн шторк	Радио, телевизийн нэвтрүүлгийн үеэр ивээн тэтгэгчийг зарлах богино (ихэвчлэн 5 сек орчим) зарлал	Billboard
43	Инфотэймэнт	Мэдээллийг цэнгээнт төрөлтэй хослуулан хүргэхийг хэлнэ.	Infotainment
44	Кабелийн телевиз	Хэрэглэгчийн телевизорт кабелийн холболтоор ТВ-ийн дохиог дамжуулан түгээх систем	Cable television (cable tv or catv)
45	Кабелийн үндсэн үйлчилгээ	Хэрэглэгчтэй байгуулсан "Үндсэн" үйлчилгээний гэрээ, сарын суурь хураамжийн үндсэн дээр үзүүлж буй кабелийн телевизийн үйлчилгээ. Үүнд Кабелийн үйлчилгээ эрхлэгчийн "Төлбөртэй" үйлчилгээ хамаарахгүй.	Basic cable service
46	Кадр	Хөдөлгөөнт дүрсийг бүрдүүлэх олон тооны хөдөлгөөнгүй дүрсүүдийн нэг	Frame / shot
47	Командын холбоо	Нэвтрүүлгийг хийж байгаа үед нэвтрүүлэгт саад болохгүйгээр ажилд оролцогч талууд хоорондоо харилцах,команд өгөх процесс. Шууд мэдээний үеэр сурвалжлагчтай ил ба ил бус хэлбэрээр харилцахад мөн энэ хэллэг хамаардаг	Talkback
48	Контент	Харилцаа холбооны сүлжээгээр дамжиж буй тэмдэгт, дохио, текст, зураг, дуу, авиа, дүрс,	Content

		бичлэг болон бүх төрлийн мэдээ, мэдээллийг электрон хэлбэрт хувиргасан бүтээл	
49	Мини цуврал	Богино хэмжээний өдөр тутмын цуврал нэвтрүүлэг, олон ангит кино, цуврал кино.	Miniseries
50	Мэдээлэл	Ямар нэг үйл явдлын талаар бүртгэгдсэн, цуглуулсан баримт, мэдлэг, эх сурвалжийг хэлнэ.	Information
51	Мэдээний сурвалжлагын групп/баг	Студийн гаднаас мэдээ бэлтгэх үүрэгтэй, сурвалжлагч, зураглаач зэрэг 3-4 хүний бүрэлдэхүүнтэй баг /заавал шууд дамжуулах албагүй ???/	Electronic news gathering (ENG)
52	Мэдээний сэдвийн дараалал	Тухайн мэдээний нэвтрүүлгийн сэдвийн дараалал/ихэвчлэн мэдээнд хэрэглэгддэг. Playlist д ордоггүй, редактор/продюссер зохиож, мэдээний серверт байрлуулна.	Rundown
53	Мэдээний толгой	Мэдээний гарчиг - тухайн мэдээний талаарх урьдчилсан ойлголтыг өгөх товч ишлэл үг, өгүүлбэрийг хэлнэ.	Headline
54	Мянгад хүргэх өртөг	Таргет үзэгчийн 1000 хүнд хүргэх зардал	Cost per thousand (CPT)
55	Найруулагч	Телевиз, киноны уран бүтээлийн найруулагч нь уран бүтээл бүтээх явцыг бүхэлд нь удирдан зохион байгуулдаг	Production director
56	Насанд хүрэгчдэд зориулсан сувгийн үйлчилгээ	18-аас дээш насны үзэгчдэд зориулсан төлбөртэй сувгийн үйлчилгээ	Adult programming service
57	Насны ангилал	Телевизийн нэвтрүүлэг үзэх үзэгчдийн насны ялгаагаар тооцсон ангилал	Age classification
58	Насны ангиллын тэмдэглэгээ	Нэвтрүүлгийн эхэнд үзүүлэх, тухайн нэвтрүүлэг нь ямар насны үзэгчид тохиромжтой болохыг илэрхийлсэн график дүрслэл. Баннер хэлбэртэй байж болдог.	Age classification symbol
59	Нийгмийн зар сурталчилгаа	Нийтийн болон улсын эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлс, энэ чиглэлээр мэдлэг, мэдээлэл олгохыг дэмжин тэтгэх зорилгоор хийгдсэн, ихэнхдээ хариу төлбөргүйгээр нэвтрүүлэх арилжааны бус сурталчилгаа	Social advertisement/ Public service advertising
60	Нийтлэл	Нийгэмд болж байгаа нийтлэг, өдөр тутмын үйл явдлын талаарх нэвтрүүлэг.	Feature
61	Нөөц зочин	Хөтөлбөрт тусгагдсан шууд/шууд бус ярилцлагын нэвтрүүлгийн төлөвлөгөөт зочин оролцож чадахгүй болсон тохиолдолд оронд нь оруулахаар бэлэн байлгаж буй хүн	Standby guest
62	Нөхөөс хөтөлбөр	Хөтөлбөрийн цагийн хуваарьт заасан үндсэн нэвтрүүлэг хооронд гарсан хоосон цагийг нөхөж оруулах богино хэмжээний хөтөлбөрийг хэлнэ. Ийм төрлийн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа 30 минутаас хэтрэхгүй байна. Хөтөлбөрийн промо, танилцуулга байх боломжтой.	Filler programming/Interstitial programming
63	Нэвтрүүлгийн промо	Дараа нь эсвэл удахгүй гарах эсвэл шинээр гарахаар төлөвлөж буй нэвтрүүлгийг танилцуулсан богино видео	Coming up, next content promo
64	Нэвтрүүлгийн хар зураг	Телевизийн аливаа нэвтрүүлгийг хийхээс өмнө зохиолын дагуу нарийвчлан үзүүлсэн хар зураг	Storyboard

65	Нэвтрүүлэг	Радио, телевизээр дамжуулах зориулалтаар бэлтгэсэн бүх төрлийн контент. /Программ гэдэг үг нь нь хэрэглэгдэж байгаа тухайн агуулгаас хамаарч хөтөлбөр, нэвтрүүлэг гэсэн 2 өөр утгыг илтгэнэ./	Programm/content/
66	Нэгж рейтингийн өртөг	Зар сурталчилгааны нэгж (ж: 30 секундын шторк) зардлыг тодорхой таргет группийн (ж: эмэгтэй 18-49 нас) дундаж рейтинг үзүүлэлтэд хуваасныг хэлнэ.	Cost per rating (CPR)
67	Нэр/гарчиг урсгах	Ихэнхдээ дэлгэцийн доороос дээш чиглэлд кино/нэвтрүүлгийн уран бүтээлчдийн багийн нэрсийг урсгадаг.	Rolling title/crawl title, running title
68	Олон нийтийн радио, телевиз	Олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, ашгийн төлөө бус радио телевизийн үйлчилгээ	Public radio and television
69	Олон талт хөтөлбөртэй телевиз/ерөнхий/	Хөтөлбөрийн бодлогын хувьд олон төрөл, чиглэлтэй телевизийг хэлнэ. Хөтөлбөр бүхэлдээ болон хөтөлбөрийн дийлэнх нь олон талт байх боломжтой. Олон талт хөтөлбөртэй телевизэд төлбөртэй телевиз хамаарахгүй бөгөөд зөвхөн зар сурталчилгааны орлогоор санхүүжих телевизийг ойлгоно.	General channel / Generalist
70	Оператор/зураглаач	Кино урлаг болон телевизийн салбарт дүрс бичлэгийн төхөөрөмжийг удирдаж байгаа мэргэжилтэн	Camera man / operator
71	Оргил цаг	Түүвэр олонлогийн хамгийн өндөр телевиз үзэлттэй байх цагийн интервалыг оргил цаг гэнэ. Судалгааны байгууллагуудын дүнгээр МУ-ын хэмжээнд ажлын өдөр 18:00-23:00, амралтын өдөр бүхэл өдөржин /12:00-22:00/ цагийг оргил цагт тооцож авч үзэж байна.	Prime time
72	Орлон тоглогч	Телевизийн нэвтрүүлэг, кинонд акробатын хүнд үзүүлбэр зэрэг аюултай хэсэгт жүжигний оронд тоглодог мэргэжлийн хүн	Stunt coordinator/stunt performer/stuntman /
73	ОТТ/интернет суурьтай контентийн үйлчилгээ/	Хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нийтийн интернетийн сүлжээгээр дамжуулан бүтээлийн санд байршуулсан бүтээл болон телевиз, суваг, радиогийн хөтөлбөрийг сонгон төлбөртэй үзэх үйлчилгээг хэлнэ.	Over the top (OTT)
74	Өөрийн бүтээл	Телевиз, суваг, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн хөтөлбөрт тусгагдсан, 3-дагч талаас нийлүүлсэн гэрээний үндсэн дээр цацаж байгаагаас бусад өөрийн санхүүжилтээр дангаар болон хамтран үйлдвэрлэсэн бүтээлийг хамруулна. Тухайн редакцийн зүгээс хөтөлбөрт тусгагдсан 3-дагч талаас нийлүүлсэн гэрээний үндсэн дээр дамжуулах хөтөлбөрт хяналт тавих үүрэгтэй бөгөөд хууль зөрчсөн тохиолдолд хариуцлагыг хамтран хүлээнэ.	Own product of the broadcasting organization
75	Өргөн нэвтрүүлгийн өрх	Өрх - Орон сууц, байшин, гэр гм нэгж байранд хамт амьдардаг нэг ба түүнээс дээш тооны хувь хүмүүс бүхий хүн ам зүйн нэгж үзүүлэлт. Өргөн нэвтрүүлгийн өрх/ ТВ өрх - Нэг ба түүнээс дээш тооны телевизортой нэгж өрхийг хэлнэ.	Household (HH)
76	Өргөн нэвтрүүлэг	Урьдчилан бэлтгэсэн хөтөлбөрийг мэдээлэл холбооны сүлжээ, төхөөрөмж ашиглан нэг төвөөс олон нийтэд нэгэн зэрэг хүргэхийг хэлнэ.	Broadcasting

		/Дараалсан хуваарийн дагуу дамжуулж буй радио, телевизийн хөтөлбөр./	
77	Пиплметр	Гэр бүлийн түвшинд, гишүүн тус бүрээр телевиз үзэлтийн байдлыг секундын нарийвчлалтай тасралтгүй бүртгэж боловсруулалт хийн гаргах боломжтой телевизорт суурилуулдаг судалгааны төхөөрөмж.	People meter
78	Пост продакшн	Бүтээл үйлдвэрлэлийн дараагийн үе шат буюу бүтээлийн нягтлах, засварлах, дуу оруулга хийх, дүрсийг хайчлах, наах, бичих зэрэг дуу дүрсийг нэгтгэх, бүтээлийг үзэгчдэд хүргэхэд бэлэн болгох үйл ажиллагаа.	Postproduction
79	Продюсер	Захиалагчийн хэрэгцээ шаардлага, редакцийн бодлогын хүрээнд төлөвлөх, бүтээх, түгээх, зах зээлд нийлүүлэх, бүтээл бий болох бүхий л үе шатад уран сайхны найруулга, агуулгын хувьд, үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, санхүүгийн хувьд удирдан зохион байгуулах, чиглүүлэх үүрэг хариуцлага, эрх мэдэл бүхий ур чадвартай хүн.	Producer
80	Промо суваг	Бусад сувгуудаар нь ямар нэвтрүүлэг шоу гарч буйг сурталчлах зорилготой кабелийн телевизийн суваг	Barker channel
81	Промо/Анонс	Идэвхжүүлэлт гэдэг үгний товч үг. Тодорхой нэг бараа, бүтээгдэхүүний борлуулалтыг өсгөхөд чиглэсэн радио, телевизийн 15-60 секундын богино хэмжээний видео хэлбэрийн сурталчилгаа	Promo/ Promotion
82	Радио	Хөтөлбөрийн дагуу бэлтгэсэн үг, дуутай агуулгыг радио давтамж ашиглан өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулан хүргэх үйлчилгээ	Radio broadcasting
83	Редактор		Editor
84	Редакци	Сонин сэтгүүлийн дугаар, ном, телевиз, радиогийн нэвтрүүлгийг бэлтгэн гаргах ажлыг хариуцдаг уран бүтээлчдийн хамт олон.	Editorial
85	Редакцийн хариуцлагын дүрэм/Редакцийн ёс зүй, хэм хэмжээний дүрэм	Хөтөлбөрийн бодлого, сэтгүүл зүйн ёс зүйн зарчим, соёл урлаг, уран сайхан, уран бүтээлийн мэргэжлийн шалгуур шаардлага, үйлдвэрлэлээс дамжуулалт хүрэх бүх үе шатад дуу дүрсийн стандарт шаардлагуудыг хангасан байх үйл ажиллагааны заавар, зөвлөмжийг редакцийн зүгээс батлан гаргасан баримт бичиг	Code
86	Савангийн дуурь	Телевизийн цуврал жүжиг	Soap opera
87	Синхрон	Аливаа үйлдлийг нэгэн цаг хугацаанд зэрэг хийхийг хэлнэ. /Телевизийн кадрт гарч байгаа хүний нүүр царайг, яриатай нь зэрэг гаргах -/ сурвалжлагчийн ярьж байгаа үйл явдалтай хамаатай этгээдээс (гэрч гм) авсан товч/шууд ярилцлагыг сурвалжлагчийн ярианы үеэр дэлгэцээр зэрэг харуулах гм олон үйлдлүүдэд хэрэглэгдэнэ/	Synchronous
88	Сонсогч	Радиогийн хөтөлбөрийг тогтмол болон тодорхой цагт, давтамжтай хүлээн авч сонсдог хүнийг сонсогч гэнэ.	Listener /radio listener

89	Студи менежер	Телевизийн уран бүтээлчдийн баг, дамжуулах хэсэг, нэвтрүүлэгт оролцогч бүх талуудад продюссерын өгсөн зааварчилгааны дагуу зохион байгуулж ажилладаг хүнийг хэлэх бөгөөд тухайн бүтээлийг хөтөлбөр, хуваарийн дагуу явагдахад байнга заавар өгч байдгаараа туслах найруулагчтай адил. Мөн студийн тайзыг цэвэр, аюулгүй байлгах, зураг авалтад шаардлагатай бүх л зүйлс бэлэн байгаа эсэх, шаардлагатай гэрэлтүүлгээс эхлэн зураг авалтын үеэр студи-д гадны чимээ шуугиан байлгахгүй байхад хүртэл анхаарал тавьж шалгадаг	The floor manager
90	Суваг	Хөтөлбөрөө олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн сүлжээгээр гэрээний үндсэн дээр дамжуулан олон нийтэд хүргэх үйлчилгээ	Channel
91	Суваг хооронд шилжих/суваг солих	Удирдлагаар телевизийн суваг хооронд хурдан шилжих, суваг солих	Surfing
92	Сувгийн багц		Channel package
93	Сурвалжлагч	Мэдээний студид бус, гаднаас үйл явдлыг мэдээлэгч. Ихэнхдээ өөр хот, аймаг, хөдөөнөөс мэдээ бэлтгэн илгээх үүрэгтэй ажилтан.	Correspondent (cor., corr., or corres.) / Reporter
94	Сурталчилгааны дуу	Ямар нэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах зорилгоор, захиалгаар хийсэн бүрэн хэмжээний дуу	Advertisement song
95	Сурталчилгааны нүүр хуудас	Нэвтрүүлгийн дундуур эсвэл төгсгөлд зар сурталчилгаа дамжуулахын өмнө үзүүлэх, зар сурталчилгаа эхэлж эсвэл дуусч байгааг илэрхийлэх богино видео дүрслэл	Break bumper
96	Сурталчилгааны шторк	Аливаа бараа, бүтээгдэхүүн, брендийг сурталчлахад чиглэсэн, үзэгчдийн анхаарлыг татаж, нөлөөлөх зорилготой хийгдсэн богино хэмжээний 20 секундээс хэтрэхгүй видео клип/ зар сурталчилгаа	Promotional spot
97	Сэтгүүлч	Тухайн редакцийн бодлого, ёс зүйн дүрэм журмын хүрээнд сэтгүүлзүйн бүтээлийг бэлтгэх, хүргэх, чиглүүлэхэд баримт мэдээлэл эрэн хайх, боловсруулах, хянан тохиолдуулах үүрэг бүхий хүн. Сэтгүүлч нь аль нэг редакцид хамаарахгүй байж болно.	Journalist
98	ТВ продюсер	Телевизийн видео бүтээлийг бүтээхэд эхнээс аваад эцсийн шат хүртэлх шаардлагатай санхүүжилтээс эхлэн бүхий л үе шатыг хариуцдаг хүн	Television producer
99	Теле худалдаа	Бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэх заавар, зөвлөгөөний хамт өөрийн телевизийн сувгаар дамжуулан нийтэд таниулан үзэгчдээс захиалга авч, гарт хүргэх арилжааны үйл ажиллагаа	Teleshopping / homeshopping
100	Телевиз/радио	Өргөн нэвтрүүлгийг цацах, дамжуулах цогц систем бүхий байгууламж өөрөөр хэлбэл олон нийтийн, арилжааны бүх төрлийн телевизийн үйлчилгээ эрхлэгч/ урт, богино долгионы радиогийн үйлчилгээ эрхлэгчдийг хэлнэ. Товчооор телевиз/радио юм. TV Station - телевиз, Radio station- радио	Station (sta. or stn)/Broadcasting station

101	Телевиз/радиоогийн олонд таниулах сувгийн нэр	Телевиз, радио нь эфирт гарахдаа үзэгч, сонсогчдод танигдах зорилгоор өөрийн сувгийн нэрийг товчилсон нэр	Station ID
102	Телевизийн шоуны зохицуулагч	ТВ-ийн ярилцлага, шоуны жүжигчид, зочдыг сонгох, төлөвлөж хуваарь гаргах, шоуны үеэр жүжигчид, нэвтрүүлэгч биеэ хэрхэн авч явах, ямар дүр байдал үзүүлэхийг заах зэрэг зохион байгуулалтын бүх арга хэмжээ авдаг хүн	Talent coordinator
103	Техникч	Телевизийн техникч нь телевизээр гарч байгаа нэвтрүүлгийн дуу, дүрсийн чанар, радиоогийн дууны чанарыг хариуцаж ажилладаг хүн	Technician
104	Титр	Телевизийн нэвтрүүлэг, кино, видеонд гарсан аливаа яриа, харилцан яриа, дэлгэц дээрх дүрсийн тайлбарыг дэлгэцийн доогуур текст хэлбэрээр гаргахыг хэлнэ	Subtitle
105	Төлбөртэй телевиз, суваг	Хэрэглэгч гэрээний үндсэн дээр өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусгай зөвшөөрөлтэй арилжааны телевиз, сувгийн хөтөлбөрийг төлбөртэй хүлээн авч үзэх үйлчилгээ <i>Төлбөртэй үзэлтийн үйлчилгээгээр ил болон далд зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг, бүтээгдэхүүн байршуулалт, арилжаа сурталчилгааны мэдээлэл, теле-худалдаа, захиалгат нэвтрүүлэг зэрэг арилжаа сурталчилгаа дамжуулдаггүй</i>	Pay television
106	Төрөл/Жанр	Өөр хоорондоо төстэй, ижил зүй тогтол, нийтлэг шинж чанар, хэв маяг бүхий нэвтрүүлгийг ангилан бүлэглэхийг жанр гэж хэлнэ.	Genre
107	Төрөлжсөн суваг	Хөтөлбөрийн агуулгын хувьд нэг сэдэв, жанрын контент бэлтгэн хүргэдэг сувгийн үйлчилгээ	Thematic channel
108	Туслах	Телевиз, киноны бүтээлийн багийн гишүүн бөгөөд бүтээл үйлдвэрлэлийн үйл явцад туслах үүрэг бүхий гол туслагч	Production assistant (p.a.)
109	Урсгал	Текст, дуу/дүрсийн кодлогдсон буюу тоон өгөгдлийг сүлжээгээр дамжуулахыг хэлнэ	Stream
110	Урсдаг мэдээ/мэдээлэл	Дэлгэцийн доогуур урсдаг мэдээ, мэдээлэл, ялангуяа мэдээний үеэр	Running message/ticker/crawler-News ticker
111	Ухраах, нөхөх		Time shift
112	Үгэн зар	Өгүүлбэрээр бичсэн эсвэл хөтөлөгч унших хэлбэрээр радио телевизээр түгээж буй зар сурталчилгаа	Announcement
113	Үзэгч	Аливаа урлаг спортын үзүүлбэр эсвэл ТВ-ийн хөтөлбөр, нэвтрүүлгийг үзсэн хэсэг бүлэг хүмүүс. ТВ үзэгчийн хувьд аливаа ТВ хөтөлбөр, нэвтрүүлгийг үзсэн үзэгчид буюу судалгааны байгууллагуудын тодорхой нөхцөлд тооцоолсон үзэгчийн тоо буюу рейтинг.	Audience
114	Үзэгчийн зан төлөв	ТВ үзэгчийн ТВ үзэхдээ зарцуулдаг хугацаа, тодорхой хугацаанд буюу хоногт, өдрийн цагуудад, 7 хоногийн гаригуудад ТВ үзэлтийн дундаж хугацаа зэрэг мэдээлэл	Audience behaviour

115	Үзэгчийн хувь	Тодорхой хугацаанд тухайн телевиз, сувгийн хөтөлбөрийг хүлээн авч үзсэн айл өрхийн /үзэгчдийн хувь хэмжээг хэлдэг. Томъёо-Телевиз(радио)гийн үзэлтийн зэрэглэл x 100/ тв,радиогийн хүлээн авах төхөөрөмжийн тоо	Share, audience share
116	Үзэгчийн хүн ам зүйн үзүүлэлт	Үзэгчдийн нас, хүйс, боловсрол зэрэг мэдээллийг хэлнэ.	Demographics (demos)
117	Үзэлт	Телевизээр гарч байгаа аливаа зүйлийг үзэх	Viewing
118	Үзэлтийн нийлбэр рейтинг (GRP)	Тухайн заасан цаг хугацаанд аль нэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зар сурталчилгааны үзэлтийн зах зээлд эзлэх хувь хэмжээ	Gross rating point (GRP)
119	Үндэсний нэвтрүүлэг	Монгол улсад бүтээсэн бүх төрлийн телевизийн бүтээл, сэтгүүл зүйн бүтээл, баримтат бүтээл, кино уран бүтээл, урлаг соёлын уран бүтээл, спортын тэмцээн уралдааны дамжуулалтыг ойлгоно. Радиогийн хувьд радиогийн хөтлөлттэй бүх нэвтрүүлэг хамаарна. Зар сурталчилгаа, арилжаа сурталчилгааны мэдээлэл хамаарахгүй.	National program/ local program, originated in
120	Үндэсний/Дотоод контент	Монгол улсад бүтээсэн бүх төрлийн телевизийн бүтээл, сэтгүүл зүйн бүтээл, баримтат бүтээл, кино уран бүтээл, урлаг соёлын уран бүтээл, спортын тэмцээн уралдааны дамжуулалтыг ойлгоно. Радиогийн хувьд радиогийн хөтлөлттэй бүх нэвтрүүлэг хамаарна. Зар сурталчилгаа, арилжаа сурталчилгааны мэдээлэл хамаарахгүй.	Local content
121	Үндэсний/Дотоод мэдээ	Тухайн хамрах хүрээнд зориулан бэлтгэсэн цаг үе, үйл явдлын мэдээ, цаг агаарын мэдээ, хөтөлбөрийн танилцуулга байна.	Local news program
122	Хадмал орчуулга/хадмал тайлбар/бичгэн барилт	Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан эсвэл ярьж буй этгээдийн яриа бүдэг эсвэл гадаад хэлээр ярьж байх тохиолдолд тухайн нэвтрүүлгийг дамжуулж байх үед эсвэл хүлээн авах үед дэлгэц дээр харуулах текст хэлбэрт хувиргасан нэвтрүүлгийн яриа	Closed caption
123	Хамрах хүрээ	Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөрийг хүлээн авах боломжтой өрхийн тоо, хүн амын эзлэх хувь-газар зүйн байршлаар	Program coverage
124	Хиймэл дагуулаар студи руу дамжуулах мэдээ	Дэд бүтэц байхгүй газраас хиймэл дагуулаар дамжуулах боломжтой явуулын станц ашиглан телевизийн төв рүүгээ мэдээ дамжуулах процесс- үзэгчдэд шууд хүргэнэ гэсэн утга бус	Satellite news (or sat newsgathering) vehicle (sng)
125	Холбоос реклам	Сурталчилгааны блокны эхлэл болон төгсгөлд байх 5 хүртэл секундын реклам	Adjacency
126	Хоцрогдолттой дамжуулал	Үндсэний хэмжээнд цацагдах цагаас өөр цагт, өөр байршилд телевизийн хөтөлбөрийг тодорхой хугацаагаар хоцроож нэвтрүүлэхийг хэлнэ.	Delayed broadcast (d.b.)
127	Хөдөлгөөнгүй дүрс	Телевизийн хувьд Стилл- гэдэг үг үйл явдлын тухайн агшинг авч буй хөдөлгөөнгүй зураг, дүрс. Мөн хэвлэмэл медиагийн хөдөлгөөнгүй дүрс авдаг зурагчдыг хэлдэг хар ярианы хэллэг байдаг.	Stills

128	Хөтлөгч	Радио, телевизийн нэвтрүүлгийг чиглүүлж, өдөөж, хөгжөөж, залж авч явах үүрэгтэй хүн	Anchor
129	Хөтөлбөр	Бүх төрлийн нэвтрүүлгийг радио, телевиз, сувгаар дамжуулахаар хуваарьт оруулсныг	Programm
130	Хөтөлбөр нийлүүлэгч/Телевиз, сувгийн үйлчилгээ эрхлэгч	Өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр бэлтгэн, нийтэд хүргэх үйлчилгээ эрхлэгч	Programm provider /tv
131	Хөтөлбөрийн стандарт	Хөтөлбөрт тавигдах ерөнхий шаардлага	Program standards
132	Хөтөлбөрийн төрөл/Формат, хэлбэр/	Хөтөлбөрийн бодлогын дагуу тодорхойлсон ерөнхий чиглэл юм./Кино, мэдээ, хөгжим, спорт гэх мэт/	Format
133	Хөтөлбөрт баримтлах зарчим	Өргөн нэвтрүүлгийн агуулгад баримтлах хэм хэмжээ	Programme Code
134	Хууль бус зар сурталчилгаа	Зар сурталчилгааны тухай хуулиар тодорхойлсон зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс суртахуунд үл нийцсэн гм далд шинж чанартай зар сурталчилгаа	Illegal advertisement
135	Хүй олны өргөн нэвтрүүлэг (ХОӨН)	Өөр хоорондоо ямар нэг холбоотой, өөрөөр хэлбэл, үндэсний болон угсаатны цөөнх, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт хүйн бүлгүүд өөр бусад тодорхой ашиг сонирхол бүхий хэсэг бүлэг хүмүүст үйлчилдэг радио, телевизийн үйлчилгээ <i>(ХОӨН нь ашгийн бус, хүй олон нь өөрөө өмчөө эзэмшиж, захиран зарцуулж, өөрсдийн сайн дурын үндсэн дээр ажиллаж, өөрсдөө удирдан өөрсдөө хянадаг байна. Санхүүжилтийн гол эх үүсвэр нь төсвийн дэмжлэг, хандив, хязгаарлагдмал зар сурталчилгаа байдаг.)</i>	Community broadcasting service
136	Хэрэглэгч	Олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгчтэй гэрээ байгуулж, телевизийн сувгуудыг хүлээн авах боломжоор хангагдсаны төлөө төлбөр төлж байгаа хүн, өрх гэр	Subscriber
137	Хэрэглэгчийн өгөгдөл	Олон сувгийн дамжуулах үйлчилгээ хүлээн авч байгаа хэрэглэгчдийн телевиз үзэлт, хэрэглээний талаарх мэдээлэл бүхий өгөгдөл. Хэрэглэгчийн өгөгдөл гаргах боломжтой хэрэглэгчийн хүлээн авах төхөөрөмж эсхүл өөр хэрэгслээр дамжуулан үзэгчийн телевиз үзэлт, хэрэглээний талаарх маш нарийн мэдээлэл бүхий томоохон дата бүхий баазыг бүрдүүлэх боломжтой байдаг	Return path data RPD
138	Хэрэглэгчийн сонгомол үйлчилгээ	Хэрэглэгчийн гэрээтэй, бүртгэлтэй хэрэглэгч өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээлийн санд байршуулсан бүтээл болон төлбөртэй сувгийг сонгон төлбөртэй үзэх үйлчилгээг хэлнэ. Төлбөрийн нөхцөл нь нэгж үзэлтийн тоо эсхүл тодорхой хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэглэгчийн сонгомол үйлчилгээгээр ил болон далд зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг, бүтээгдэхүүн байршуулалт, арилжаа сурталчилгааны мэдээлэл, теле-худалдаа, захиалгат нэвтрүүлэг зэрэг арилжаа сурталчилгаа дамжуулахгүй.	On-demand service

139	Цаг үеийн мэдээний хөтөлбөр	Цаг үеийн шинж чанартай, өдөр тутмын, нийгэмд болж буй үйл явдлын талаарх сурвалжлага, мэдээг хөтлөгчийн хөтлөлттэй хүргэхийг хэлнэ.	Hard news
140	Цагийн үечлэл	Программын албанд гаргасан хөтөлбөрийн нарийвчилсан цагийн хуваарьт туссан тухайн нэвтрүүлгийг хуваасан цагийн үечлэл /Зар сурталчилгаа авахад ихэвчлэн хэрэглэгддэг/	Time slot
141	Цоолох	Нэг дүрсийг нөгөө дээр давхарлаж нийлмэл дүрс гаргах (цул өнгийн фонд дээр (ногоон) дүрс давхарлах)	Superimposition (super)
142	Шууд дамжуулалт	Үйл явдлыг газар дээрээс нь сурвалжлах, дамжуулах, хугацааны хоцрогдолгүй үзэгчдэд хүргэх үйл явц нэгэн зэрэг өрнөхийг шууд дамжуулалт гэнэ. Студид болон студийн гаднаас шууд дамжуулалт хийх боломжтой. Үйл явдлыг шуурхай хүргэснээр үзэгчдэд үйл явдлын гэрч болох мэдрэмжийг бий болгох боломжтой байдаг. Шууд дамжуулалт нь шууд эфирийг бий болгодог.	Live
143	Шууд сурвалжлага	Болж буй үйл явдлын мэдээ, сурвалжлагыг байгаа өнгө төрх, дуу чимээтэйгээр нь ямар нэгэн дуу оруулалтгүйгээр үзэгч, сонсогчид хүргэх ажиллагаа	Live reporting
144	Шууд эфир	Болж буй үйл явдлын мэдээ, сурвалжлагыг байгаа өнгө төрх, дуу чимээтэйгээр нь ямар нэгэн дуу оруулалтгүй хүргэхийг шууд буюу лайв сурвалжлага гэнэ.	On air / live
145	Шууд яриа	Хөтлөгч студиэс өөр байршилд буй сурвалжлагчтай эфирийн дамжууллын үед шууд холбогдон ярих үйл явц	Cross-talk
146	Шуурхай мэдээ	Мэдээний баг, агентлагаас төлөвлөгөөт хөтөлбөрийн дундуур болж буй цаг үеийн шинжтэй үйл явдлыг шууд мэдээлэх үйл явц.	Breaking news
147	Эвлүүлгийн өрөө	Бичиж авсан дүрснээс тодорхой хэсгийг сонгон шаардлагатай дэс дараалалд оруулж, уг дүрснүүд утга, агуулгын хувьд нийлэн үйл явдал тасралтгүй үргэлжилж буй мэт сэтгэгдэл төрүүлэхийн тулд хийж буй үйлдлийг эвлүүлэг гэх ба уг үйлдлийг хийдэг өрөөг эвлүүлгийн өрөө гэнэ.	Editing room
148	Эвлүүлэг	Бичиж авсан дүрснээс тодорхой хэсгийг сонгон шаардлагатай дэс дараалалд оруулж, уг дүрснүүд утга, агуулгын хувьд нийлэн үйл явдал тасралтгүй үргэлжилж буй мэт сэтгэгдэл төрүүлэхийн тулд хийж буй үйлдэл	Editing
149	Эвлүүлэгч		Editor
150	Эфирийн хоног	Нэг хоногт радио эсвэл телевизийн нэвтрүүлэх станцын эхлэх цаг минутаас дуусах цаг минут хүртэл үргэлжлэх хугацаа.	Broadcast day